



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ
ТОГТООЛ

2023 оны 11 сарын 20 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Ард түмнээ хайрлая намын нэрийг
Ард түмний хүч нам болгож өөрчилсөн
намын дүрмийн өөрчлөлтийг улсын
бүртгэлд бүртгүүлэх өргөдлийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Ганзориг даргалж, танхимын тэргүүн Г.Алтанчимэг, Д.Мөнхтуяа, шүүгч Б.Амарбаясгалан, Г.Банзрагч, Н.Батзориг, Д.Батбаатар, С.Батдэлгэр, М.Батсуурь, Х.Батсүрэн, Б.Батцэрэн, Н.Батчимэг, Н.Баярмаа, П.Золзаяа, М.Пүрэвсүрэн, П.Соёл-Эрдэнэ, Б.Цогт, Ц.Цогт, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсүвд нарын бүрэлдэхүүнтэй хийсэн хуралдаанаар,

Ард түмнээ хайрлая намаас гаргасан “намын нэр өөрчилсөн дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх тухай” өргөдлийг шүүгч Г.Банзрагчийн илтгэснээр хэлэлцээд

ТОДОРХОЙЛОХ нь:

Ард түмнээ хайрлая намыг төлөөлж тус намын дарга Л.Аззаяагаас 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр Улсын дээд шүүхэд өргөдөл гаргасан.

Уг өргөдөлд “... Тус намын ээлжит бус Их чуулган 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж, намын оноосон нэрийг Ард түмний хүч нам хэмээн өөрчлөх, дүрэм батлах шийдвэр гаргасан. Иймд Ард түмнээ хайрлая намын оноосон нэрийн бүртгэлийг Ард түмний хүч нам хэмээн шинэчлэн бүртгүүлэх, намын дүрэм бүртгүүлэх хүсэлт гаргаж байна. Хуульд заасны дагуу хүлээн авч, бүртгэж өгнө үү” гээд нийт 94 хуудас бүхий 34 баримт, 2 ширхэг CD, нэмэлт 4 хуудас бүхий 3 баримтыг ирүүлжээ.

Дээрх өргөдөл, хавсралтаар ирүүлсэн баримтууд нь Улс төрийн намын тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын Хавсралт №2А-д заасан бүрдүүлбэрийн шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, журмын 3.18-д зааснаар шүүгчээс бэлтгэл ажлыг гүйцэтгэн, Нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцүүлэх саналыг гаргасны дагуу өргөдлийг хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаас Ард түмнээ хайрлая намын нэрийг Ард түмний хүч нам гэж өөрчилсөн намын дүрмийн өөрчлөлтийг дараах үндэслэлээр бүртгэхээр шийдвэрлэлээ.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.6, 10 дугаар зүйлийн 10.1.6, 10.1.8-д тус тус зааснаар намын дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлт нь улс төрийн намын улсын бүртгэл, хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулгад заавал тусгах мэдээлэлд хамаарах тул өргөдөлд дурдсан асуудал нь Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Улс төрийн намын бүртгэл хөтлөх журам”-ын 1.4, 3.12-т заасан “намын баримт бичгийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт” гэсэн бүртгэлийн төрөлд хамаарна.

Ард түмнээ хайрлая намын дарга Л.Аззаяагаас намын нэр өөрчилсөн дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх тухай өргөдлийг гаргасан нь Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д, мөн уг өргөдлийг 2023 оны 10 дугаар сарын 30-ны өдөр ирүүлсэн нь Улс төрийн намын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т тус тус нийцжээ.

Улсын дээд шүүхийн шүүх хуралдааны 2015 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор Ард түмнээ хайрлая намыг улсын бүртгэлд бүртгэсэн бөгөөд тус шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 13 дугаар тогтоолоор намын даргаар Л.Аззаяаг бүртгэсэн бүртгэл хүчин төгөлдөр байна.

Ард түмнээ хайрлая намын дүрмийн 9.1.4.4-т зааснаар “Намын нэрийг өөрчлөх, ...” нь тус намын удирдах дээд байгууллага болох Их чуулганы бүрэн эрхэд хамаарна. Намын ээлжит бус Их чуулган дүрэмд заасны дагуу дараах журмаар хуралдаж, холбогдох шийдвэрийг гаргажээ. Үүнд:

1.Намын дүрмийн 9.2.4-т “Бага чуулганы хуралдааныг Намын дарга Тэргүүлэгчдийн санаачилгаар, эсхүл намын Бага чуулганы гишүүдийн гуравны нэг шаардсанаар зарлан хуралдуулж болно” гэж заасны дагуу намын дарга Л.Аззаяа 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 04 дүгээр тушаалаар “Намын ээлжит бус Бага чуулганы хуралдааныг 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр Улаанбаатар хотод хуралдуулах”-аар шийдвэрлэсэн нь дүрмийн дээрх заалт болон уг тушаалын үндэслэлд заасан 9.2.3, 9.1.8-д тус тус нийцсэн байна.

2.Намын даргын дээрх тушаалын дагуу намын ээлжит бус Бага чуулган 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж, нийт 4 шийдвэр гаргасны дотор 03 дугаар тогтоолоор намын ээлжит бус Их чуулганыг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хийхээр товлож, “Намын цахим хуудаст байршуулсан урилгын дагуу 2023 оны 10 дугаар сарын 19-ний өдрөөс өмнө ээлжит бус Их чуулганд оролцохоо илэрхийлж зохион байгуулах комисстой биечлэн холбогдсон намын гишүүдийг намын ээлжит бус Их чуулганы төлөөлөгчөөр сонгогдсонд тооцохоор журамлаж, төлөөлөгчийн тоог тогтоосон нь тус намын дүрмийн 9.1.3-т “Их чуулган хуралдах тов, төлөөлөгчдийн тоо, тэднийг сонгох журмыг Бага чуулган тогтооно.” гэсэнтэй нийцжээ.

Намын (ээлжит бус) Бага чуулганы эрх зүйн байдал нь тус намын дүрмийн 9.2.1.“Намын Их чуулган нь Бага чуулганыг 15 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэйгээр дараагийн Их чуулган хүртэлх хугацаагаар байгуулна...”, 9.2.3.“Бага чуулганы ээлжит хуралдааныг хоёр жил тутам зарлан хуралдуулах бөгөөд шаардлагатай бол ээлжит бус чуулган зарлан хуралдуулж болно”, 9.2.6.“Нийт гишүүдийн олонхи нь оролцож байгаа бол Бага чуулганыг хүчинтэйд тооцно” зэрэг зохицуулалтаар тодорхойлогдоно.

Ард түмнээ хайрлая намын III Их чуулган 2023 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр хуралдаж, 06 дугаар тогтоолоор намын Бага чуулганы гишүүдээр Л.Аззаяа,

М.Энхбат, Ц.Жимбээгалсан, Л.Ишханд, Н.Жаргалсайхан, Ж.Намнансүрэн, Б.Март, Б.Батцэцэг, Б.Бурмаа, А.Саранбаяр нарын 10 хүнийг сонгожээ. Эдгээрээс 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн хуралдаанд 9 гишүүн нь оролцож, холбогдох шийдвэрүүдийг 100 хувийн саналаар гаргасан нь өргөдөлд хавсарган ирүүлсэн баримтуудаар (ирцийн бүртгэл, хуралдааны тэмдэглэл, бичлэг/CD, фото зураг г.м.) тогтоогдож байх тул дүрмийн 9.2.6-д “Нийт гишүүдийн олонхи нь оролцож байгаа бол Бага чуулганыг хүчинтэйд тооцно” гэсний дагуу тухайн өдрийн намын ээлжит бус Бага чуулган, түүнээс гаргасан шийдвэрүүдийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

Мөн намын Их чуулганыг 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хийхээр шийдвэрлэсэн нь дүрмийн 9.1.2-т заасан “21 хоногийн өмнө шийдвэр гаргах” шаардлагыг хангасан бөгөөд намын гишүүдэд хурлын зар болон төлөөлөгчөөр сонгогдох журмыг мэдэгдсэн урилга, хуралд оролцохоо мэдэгдсэн гишүүдийн баримт, сонгогдсон төлөөлөгчдийн бүртгэл зэрэг баримтыг ирүүлсэн байна.

3.Намын ээлжит бус Их чуулган төвлөсөн өдрөө буюу 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хуралдаж, сонгогдсон 40 төлөөлөгч бүгд хүрэлцэн ирж, 100.0 хувийн ирцтэйгээр хуралдаж, шийдвэр гаргасан нь (хуралдааны тэмдэглэл, төлөөлөгчдийн бүртгэл (хүснэгт1), фото зураг, CD бичлэг зэрэг баримтаар нотлогдоно) дүрмийн 9.1.5-д “Их чуулганд сонгогдсон нийт төлөөлөгчдийн олонхи нь оролцож байгаа бол Их чуулганыг хүчинтэйд тооцно.” гэсэн шаардлагыг хангаж байна.

Ард түмнээ хайрлая намын дүрэмд Их чуулганд оролцох төлөөлөгчдийг сонгох журмын талаар тусгайлсан зохицуулалт байхгүй, Бага чуулган тухайн асуудлаар шийдвэр гаргах эрхтэй байхаар зохицуулсныг (Дүрмийн 9.1.3) дурдах нь зүйтэй.

Иймд намын ээлжит бус Их чуулганы 2023 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн “Намын нэр өөрчлөх, дүрэм батлах тухай” 05 дугаар тогтоолоор Ард түмнээ хайрлая намын дүрмийг Ард түмний хүч намын дүрэм байхаар тогтоож, уг дүрэм болон тамга, тэмдэг, бэлгэдэл, далбаанд Ард түмнээ хайрлая нам гэж бичигдсэнийг Ард түмний хүч нам гэсэн нэрээр сольж, Ард түмний хүч намын дүрмийг хавсралтаар баталсан нь Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.“Нам үйл ажиллагаандаа дараахь нийтлэг зарчмыг баримтална:” 5.1.4.“дотоод асуудлаа ардчилсан зарчмыг баримтлан олонхийн саналаар шийдвэрлэх”, 6 дугаар зүйлийн 6.1.“Нам оноосон нэртэй байх бөгөөд түүний төгсгөлд “нам” гэсэн ерөнхий нэрийг заавал хэрэглэнэ.”, 6.2.“Намын бүтэн болон товчилсон нэр нь байгууллага, аж ахуйн нэгж, болон бусад намын нэртэй адил байхыг, түүнчлэн намыг хүний нэрээр нэрлэхийг хориглоно.”, 13 дугаар зүйлийн 13.2. “Дараахь асуудлыг зөвхөн намын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ:”, 13.2.3.“...намын нэрийг өөрчлөх.” гэж заасантай болон тус намын дүрэмд нийцсэн байх тул бүртгэх нь зүйтэй байна.

Өргөдөлд Өдрийн сонины 2023 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн №032 (7152) дугаарт Ард түмнээ хайрлая нам оноосон нэр өөрчилснийг зарлуулсан зар, хуулийн этгээдийн нэрийн баталгаажуулалт зэрэг шаардагдах бусад баримтыг хавсарган ирүүлсэн болно.

Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.8, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Улс төрийн намын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 13 дугаар зүйлийн 13.2.3-т заасныг тус тус баримтлан Ард түмнээ хайрлая намын нэрийг Ард түмний хүч нам гэж өөрчлөн бүртгэсүгэй.

2.Өргөдөл гаргагчаас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 150,000 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
ЕРӨНХИЙ ШҮҮГЧ

Д.ГАНЗОРИГ

ИЛТГЭГЧ ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ